

**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН
2014 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ
ТАЙЛАГНАСАН ТУХАЙ ХЯНАЛТЫН ХУУДАС**

/2014 оны 06 дугаар сарын 30-ны байдлаар/

2014 оны 06 дугаар сарын 30-ны өдөр

№	Гүйцэтгэх ажлын чиглэл	Үзэж танилцах чиглэл	Танилцах ажил	Танилцсан тухай
1.	1. Том төрөөс ухаалаг төр рүү" Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгыг дэмжиж Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Монгол Улсын Төрийн албаны зөвлөлөөс	Том төрөөс ухаалаг төр рүү" чуулганаас гарсан санаачлагыг дэмжиж Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Монгол Улсын Төрийн албаны зөвлөлөөс гаргасан	Зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлыг хэрхэн зохион байгуулсан, төлөвлөж хийсэн үйл ажиллагаа	Төрийн албаны зөвлөлөөс гаргасан зөвлөмжийг 17 сум, 6 тосгон, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэлэтс агентлагуудад хүргүүлж, түүний мөрөөр арга хэмжээ авч ажиллахыг үүрэг чиглэл болголоо. Энэхүү зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд орон нутгийн "Миний Монгол" телевизээр долоо хоног бүрийн баасан гарагийн 17.00 цагт "Иргэдээ сонсьё" шууд нэвтрүүлгийг аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний 9 хэлтэс, агентлагууд хуваарийн дагуу оролцож, хариуцсан салбар чиглэлийн дагуу иргэдийн санал хүсэлтийг хүлээн авч шуурхай шийдвэрлэх ажлыг шат дараатай зохион байгуулж хэвшээд байна.
2.	гаргасан зөвлөмжийн дагуу гүйцэтгэж буй ажилтай танилцаж, арга зүйн зөвлөмж өгөх	зөвлөмжийн дагуу зохион байгуулсан ажил	Хэлэлцүүлэг зохион байгуулсан байгууллага, албан хаагчдын тоо	Хэлэлцүүлгийг 17 сум, аймгийн хэмжээнд зохион байгуулсан. Үүнд нийт сум орон нутгийн 184 байгууллагын 3100 гаруй ажилтан албан хаагчид хамрагдлаа. Тухайлбал: Баянгол сумын хэмжээнд төр төсвийн 10 байгууллагын 112 төрийн албан хаагч оролцсон "Ээлтэй үйлчилгээг- Баянголчууддаа" хэлэлцүүлэг, зөвлөгөөнийг зохион байгуулж 9 заалт бүхий зөвлөмжийг гарган хэрэгжүүлэн ажиллаж байна. Мөн "Иргэдээ сонсох цаг" арга хэмжээг зохион байгуулж 98 иргэн хамрагдаж, 29 иргэний санал хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэсэн байх жишээтэйгээр сум бүр тодорхой арга хэмжээг зохион байгуулан тайлагналаа.
3.	2.Төрийн албаны тухай хууль болон төрийн албаны стандарт, "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам"-д заасан чиг үүргийн хэрэгжилттэй	Салбар зөвлөлийн дотоод зохион байгуулалт	Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн гишүүдийн ажил үүргийн хуваарийг баталсан эсэх	Төрийн албаны зөвлөлийн шийдвэрээр аймгийн Төрийн албаны салбар зөвлөл 11 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж байна. Салбар зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга, гишүүд журмын хүрээнд ажил үүргийн хуваарийг шинэчлэн баталж мөрдөн ажиллаж байна. "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам"-д заасан чиг үүргийн дагуу хуралдаан, санал өргөдөл, гомдол, төрийн албаны мэргэшлийн шалгалт зохион байгуулах шийдвэрлэх ажлын хэсэгт хариуцсан салбар чиг үүргийн дагуу томилогдон ажиллаж байна.

4.	танилцаж, арга зүйн зөвлөмж өгөх;		Салбар зөвлөл хуралдааны дэг тогтоосон эсэх	Төрийн албаны салбар зөвлөл нь хуралдааны дэгийг батлан хэрэгжүүлж байна.
5.		Салбар зөвлөлийн 2013 оны хуралдаан	Хуралдсан тоо, хэлэлцсэн асуудал	2013 онд нийт 4 удаа хуралдаж 12 асуудлыг хэлэлцсэн.
6.	Хуралдаанаас гарсан шийдвэрийн хэрэгжилт тооцсон байдал		Хуралдаанаас гаргасан 12 асуудлын дагуу 4 тогтоол, 4 албан бичгийг холбогдох газруудад хүргүүлж шийдвэрийн хэрэгжилт 96 хувийн биелэлтэй байна.	
7.	Хуралдааны тэмдэглэл хөтөлсөн эсэх, хурлын баримт бичгийн эмх цэгц		Хуралдааны тэмдэглэлийг албан хэрэг хөтлөлтийн стандартын дагуу тухай бүр хөтөлж баримтжуулан архивлаад байна.	
8.	Салбар зөвлөлийг чадавхижуулах талаар төлөвлөж хийсэн ажил, үйл ажиллагааны төлөвлөлт	Салбар зөвлөлийг чадавхижуулах талаар 2014 онд авч хэрэгжүүлэхээр төлөвлөсөн үйл ажиллагаа (тусгайлсан хөтөлбөр, төлөвлөгөөтэй эсэх)	Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн 2014 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн 01 дугаар тогтоолоор 2014 оныг <u>“Төрийн албан хаагчийн ажлын хариуцлага, ёс зүйг дээшлүүлэх жил”</u> болгон зарлаж түүнийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 15 багц ажлын чиглэлийг боловсруулан сум, агентлагуудад хүргүүлэн түүний хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллаж байна.	
9.	Хууль, журам, заавар, төрийн албаны стандартыг хэрэгжүүлэх асуудлаар Төрийн байгууллагуудад арга зүйн зөвлөгөө өгч ажилласан байдал	Төрийн байгууллагуудад арга зүйн зөвлөгөө өгөх асуудлаар 2014 онд төлөвлөж хийж гүйцэтгэсэн ажил, /Зөвлөгөө өгөх хуваарь, зөвлөмж өгсөн тухай тэмдэглэл, хөтөлбөр, бусад баримт/	Зарласан жилийн хүрээнд 2014 оны эхний хагас жилийн байдлаар төрийн жинхэнэ албаны хүний нөөцийн хэрэгцээг төлөвлөн, хэрэгжүүлж буй байдлыг шалган зааварчлах зорилгоор 3 бүлгийн 14 ажил арга хэмжээг тусгасан удирдамжийн хүрээнд салбар зөвлөлийн гишүүнээр ахлуулсан 4 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг Зүүнбүрэн, Шаамар, Цагааннуур, Сант, Баруунбүрэн, Орхон, Түшиг, Алтанбулаг, Жавхлант, Сайхан сумдын Засаг даргын Тамгын газарт ажиллаж төрийн албаны стандартыг хэрэгжүүлэх асуудлаар заавар зөвлөгөө өгч ажиллалаа. Энэхүү ажлыг сүүлийн хагас жилд үлдсэн сум, хэлтэс агентлагуудад шалган зааварчилж жилийн эцсээр үнэлгээ дүгнэлт гарган үр дүнг тооцон ажиллах юм.	
10.		2014 онд арга зүйн зөвлөгөө өгсөн төрийн байгууллагын тоо /Албан бичгээр өгсөн зөвлөмж/	<u>“Ээлтэй үйлчилгээг иргэн танд”</u> арга хэмжээнд аймгийн Засаг даргын эрхлэх аасуудлын хүрээний хэлтэс агентлагуудын мэргэжилтнүүдийн хамруулан 25-30 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсгийг салбар зөвлөлийн гишүүдийг 7 хоног бүрээр ээжлүүлэн ахлуулж нийт сумдад 2014 оны 06 дугаар сарын 02-23-ны өдрүүдэд батлагдсан удирдамж, хуваарийн дагуу зохион байгуулж, сумдын төр, төсвийн 87 байгууллагын үйл ажиллагааны явц байдалтай танилцаж заавар зөвлөгөө өгч ажиллалаа. Мөн аймгийн	

				Засаг даргын “Нэрэмжит үзлэг”, “Шалган туслах” арга хэмжээг Сайхан, Алтанбулаг, Шаамар сум, Дулаанхаан, Номгон тосгонд нийт 5 бүлэг 17 шалгуур үзүүлэлт бүхий заалтын дагуу шалган үнэлгээ өгч түүний мөрөөр авах арга хэмжээний зөвлөмжийг дээрх сумдад албан бичгээр хүргүүлж ажилласан.
		Төрийн байгууллагуудад хууль, журам, заавар, төрийн албаны стандартын хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан байдал	Хууль, журам, заавар төрийн албаны стандартын хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийхээр 2014 онд төлөвлөсөн үйл ажиллагаа, түүний хэрэгжилт	Төрийн албаны салбар зөвлөлийн 2014 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд “Төрийн албаны тухай хууль тогтоомж, стандартыг хэрэгжүүлэхэд анхаарч, нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд сурталчлах ажлыг зохион байгуулах” гэсэн зорилтын хэрэгжүүлэх ажлын хүрээнд хууль, журам, заавар төрийн албаны стандартын хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийх ажлыг нэг гол үзүүлэлт болгон тусгаж хэрэгжилтийг ханган ажиллаж байна.
			Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний болон нутгийн захиргааны байгууллагууд батлагдсан бүтэц орон тоогоор ажиллаж буй эсэх, Төрийн албан хаагчийг томилж, чөлөөлсөн тухай эрх бүхий албан тушаалтны шийдвэрийг хянаж, зөвлөмж өгсөн ажил	Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний 21 хэлтэс агентлагт батлагдсан бүтэц, орон тоо, төсвийн хүрээнд нийт 961 төрийн албан хаагч, 17 сумын Засаг даргын Тамгын газарт батлагдсан орон тооны дагуу 12-20 хүний бүрэлдэхүүнтэй 280 гаруй албан хаагч ажиллаж байна. Орон нутгийн төрийн захиргааны байгууллагын төсвийн шууд захирагч нарын төрийн албан хаагчийн хүний нөөцийн холбогдол бүхий шийдвэрийн эрх зүйн үндэслэлийг хэрхэн хангаж буй байдалд “Шалган туслах” ажил арга хэмжээ, аймгийн “Засаг даргын нэрэмжит үзлэг” шалгалтын хүрээнд заавар зөвлөгөө өгч зөвлөн туслах үйлчилгээг үзүүлж байна.
11.	Өргөдөл гомдлын шийдвэрлэлт	Салбар зөвлөлд 2014 онд ирсэн өргөдөл, түүний шийдвэрлэлт		Аймгийн Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд Төрийн албатай холбоотой асуудлаар 6 төрийн албан хаагчийн өргөдөл, гомдол ирснийг бүртгэн холбогдох хууль журмын дагуу тухай бүр нь Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн гишүүдээр ахлуулсан ажлын хэсэг томилон дүгнэлт гаргуулж, салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэн хуулийн хугацаанд нь шийдвэрлэж ажиллалаа
12.				
13.	Ёс зүйн хэм хэмжээг сахиулахтай холбогдсон	Тухай аймаг хэдэн байгууллагад Ёс зүйн хорооны ажилладаг		Аймгийн хэмжээнд 17 сум, 6 тосгоны төрийн захиргааны байгууллагуудад 3-7 хүний бүрэлдэхүүнтэй 23 ёс зүйн хороо ажиллаж байна.
14.	зөвлөгөө өгөх, Ёс зүйн хороог арга	Ёс зүйн хэм хэмжээг сахиулахтай холбогдсон асуудлаар		Ёс зүйн хэм хэмжээний эрх зүйн акт, дүрэм, журам, аймгийн хэмжээний нийт ёс хороодын бүрэлдэхүүний хүний тоо, нэр, албан тушаал, зэргийн нэгтгэсэн судалгааг багтаасан “Төрийн албан

	зүйн удирдлагаар хангах	зохион байгуулсан ажил, Арга зүйн зөвлөмж өгч ажилласан үйл ажиллагаа /зөвлөмж өгсөн тухай тэмдэглэл, хөтөлбөр, бусад баримт/	хаагчийн ёс зүйн гарын авлага” эмхэтгэл номыг гаргаж, ёс зүйн хороодод хуваарилан өгч, арга зүйгээр ханган ажиллаж байна. <u>“Ил тод, ээлтэй, хариуцлагатай үйлчилгээ”</u> сэдэвт авлигын эсрэг олон нийтийн хэлэлцүүлгийг 2014 оны 05 дугаар сарын 08-ны өдөр иргэд, авлигатай тэмцэх төрийн бус байгууллагын сүлжээтэй хамтран зохион байгуулж 17 сумын иргэдийн төлөөллийг оролцууллаа. Хэлэлцүүлгийн явц байдал, гаргасан шийдвэрийг сурталчлах орон нутгийн “Иргэн танаа” сонины тусгай дугаар гарган олон нийтийн хүртээл болголоо. <u>“Төрийн албан хаагчийн ажлын хариуцлага, ёс зүйг дээшлүүлэх жил”</u> -ийн хүрээнд Жавхлант, Баянгол сумдад зохион байгуулагдсан төрийн албан хаагчдын нэгдсэн зөвлөгөөнд оролцож төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм, авлига, нийтийн ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар эрх зүйн сургалт зохион байгууллаа. Мөн салбар зөвлөлийн төлөвлөгөөнд сумдын Засаг даргын Тамгын газрын болон хэлтэс, агентлагуудын авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөлтийн байдалд шалган зааварчилж үнэлгээ дүгнэлт өгөх арга хэмжээг тусган хэрэгжилтийг ханган ажиллаж байна.
15.		Ёс зүйн маргааны шийдвэрлэлт /хурлын тэмдэглэл, гарсан шийдвэр, түүний хэрэгжилт/	2014 оны эхний хагас жилийн байдлаар ёс зүйн зөрчил дутагдал гараагүй байна.
16.		Ёс зүйн зөрчлийн мэдээг хагас бүтэн жилээр ТАЗ-д ирүүлсэн эсэх /7, 1 сарын 10/	2013 онд хагас бүтэн жилээр мэдээг холбогдох маягтын дагуу хугацаанд нь гаргаж хүргүүлсэн.
17.	Сургалтын хөтөлбөр	Хөтөлбөр батлуулж хэрэгжүүлж байгаа эсэх	Төрийн албаны өөрчлөлт, шинэчлэлтийн өнөөгийн чиг хандлага нь мэдлэг чадвартай мэргэшсэн төрийн албан хаагчдаар иргэдэд чанартай, хүртээмжтэй төрийн үйлчилгээг үзүүлэх хэрэгцээ шаардлагын үүднээс <u>“Төрийн албан хаагчийн мэдлэг чадвар”</u> хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор нийт сум, агентлагуудад өөрсдийн онцлогт нийцүүлсэн сургалтын хөтөлбөрийг боловсруулах үүрэг, чиглэлийг өгч, хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллалаа.
18.		Хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөтэй эсэх	<u>“Төрийн албан хаагчийн мэдлэг чадвар”</u> хөтөлбөрийг хэрэгжүүлэх нэгдсэн арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг эрчимжүүлэх арга хэмжээг авч ажиллаж байна.

19.			Хөтөлбөрийн явц, үр дүнг тооцсон эсэх	Тайлант хугацаанд Удирдлагын Академийн төрийн удирдлагын магистрийн сургалтанд 1, төрийн болон нийгмийн удирдлагаар мэргэшүүлэх менежерийн сургалтанд 4, Удирдлагын Академийн богино хугацааны зорилтот сургалт, мөн харъяалах дээд байгууллагын төлөвлөгөөт 5 удаагийн сургалтанд 23, аймаг орон нутгийн хэмжээнд зохион байгуулагдсан сургалт, семинарт нийт давхардсан тоогоор 897 төрийн албан хаагч хамрагдсан байна. “Төрийн албан хаагчийн мэдлэг чадвар” аймгийн хөтөлбөрийн хэрэгжилтэнд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг жил бүр <u>аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлж, 2012 оны жилийн эцсийн байдлаар хөтөлбөрийн хэрэгжилт 92.6, 2013 оны жилийн эцсийн байдлаар 93.4 хувийн биелэлттэй үнэлэгдсэн.</u>
20.			Төрийн байгууллагуудад хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэхэд мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлсэн эсэх /арга зүйн зөвлөмж өгсөн тухай тэмдэглэл, цагийн хуваарь, арга зүйн материал/	Төрийн байгууллага бүрт хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх талаар үүрэг чиглэл өгсөн хэдий ч бүрэн хангалттай түвшинлд хийгдэхгүй байна. Байгууллага сум бүр харилцан адилгүй сургалтын төлөвлөгөө, хүний нөөцийн хөгжлийн төлөвлөгөө, аймгийн батлагдсан хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган хэрэгжүүлэн ажиллаж байна.
21.	Ажиллах нөхцөл нийгмийн баталгаа хангах хөтөлбөр		Хөтөлбөр батлуулж хэрэгжүүлж байгаа эсэх	2009 оноосТөрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг аймгийн Засаг даргын захирамжаар шинэчлэн баталж мөрдөн ажиллаж байна. Энэхүү хөтөлбөр нь төрийн албаны үйл ажиллагааг хэвийн тасралтгүй явуулахад төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгаа, эрүүл мэндийг хамгаалан хангахтай холбоотой асуудлыг шийдвэрлэж, хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлсон.
22.			Хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөтэй эсэх	Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө жил бүрийн эхэнд боловсруулан мөрдөн ажиллаж байна. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт 89,5 хувийн биелэлттэй байна.
23.			Хөтөлбөрийн явц, үр дүнг тооцсон эсэх	Энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд төрийн албан хаагчдыг шинээр орон сууц барих, худалдан авах, амьжиргааны

				<p>чадавхийг дээшлүүлэх зорилгоор зээл авахад төрийн байгууллагуудын зүгээс банкуудтай гэрээ байгуулан баталгаа гаргаж, хамтран ажиллаж байна.</p> <p>“Төрийн албан хаагчийн 4000 айлын орон сууц” хөтөлбөрийн хүрээнд 2009 онд Орон сууц санхүүжилтийн корпорацийн санхүүжилтээр аймаг, сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал, аймаг, сумын Засаг даргын Тамгын газар Аймгийн Аудитын газрын 10, Эрүүл мэндийн салбарын буюу аймгийн нэгдсэн эмнэлэг, сумдын эмнэлгийн 23, Боловсролын салбарын буюу сургууль, цэцэрлэгийн багш ажилтнуудын 74 албан хаагч Улаанбаатар хот болон орон нутагт баригдсан орон сууцанд хамрагдсан.</p> <p>Аймгийн төв Сүхбаатар суманд баригдсан 30, 20, 15 айлын орон сууц, Баруунбүрэн суманд 4 айлын, Сант суманд 4 айлын орон сууц, Шаамар суманд “Болд төмөр-Ерөө гол” компанийн хөрөнгө оруулалтаар 12 айлын орон сууц, Орхон суманд “Тогтвортой амьжиргаа” төслийн санхүүжилтээр төрийн албан хаагчдын 4 айлын орон сууц, Мандал сумын 48 айлын орон сууц ашиглалтанд орсноор төрийн албан хаагчдыг орон сууцаар хамруулах нөхцөл бүрдсэн.</p> <p>Орон сууц, хашаа байшин худалдаж авсан болон хүүхдийн сургалтын төлбөр төлсөн төрийн албан хаагчид Татварын хуулийн дагуу татварын хөнгөлөлтөнд хамрагдаж 2010 онд 1330 албан хаагч 210707,3 мянган төгрөгийн, 2011 онд 1879 албан хаагч 261186,9 мянган төгрөгийн, 2012 онд 2327 албан хаагч 530641,4 мянган төгрөгийн, 2013 онд 2779 албан хаагч 1260558,9 мянган төгрөгийн хөнгөлөлт эдэлсэн байна.</p>
24.			<p>Төрийн байгууллагууд хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэхэд мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлсэн ажиллагаа /арга зүйн зөвлөмж өгсөн тухай тэмдэглэл, цагийн хуваарь, арга зүйн материал/</p>	<p>Төр, төсвийн байгууллагууд төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах асуудлыг байгууллагынхаа хөдөлмөрийн дотоод журманд хамт олноороо хэлэлцүүлэн баталж мөрдөн ажиллаж байна. Аймгийн Засаг даргын нэрэмжит үзлэг, шалган туслах ажлын удирдамжинд хөтөлбөрийн хэрэгжилтийн явц байдлыг шалган зааварлах заалтыг тусган арга зүйн зөвлөгөө өгч зөвлөмж өгч ажиллаж байна.</p>

25.		Төрийн албан хаагчийн хувийн хэрэг	Төрийн албан хаагчийн хувийн бүрдүүлэлт баяжилт, зөвлөмж	Төрийн албан хаагчийн хувийн хэргийн бүрдүүлэлт, баяжуулалтанд онцгойлон анхаарч хувийн хэргийг жигдрүүлэх, төрийн жинхэнэ албан хаагчийн хувьд <u>шалгалтанд тэнцсэнийг нотлох баримт болон тангаргийн хүүдсыг баталгаажуулж хийсэн эсэхийг хянан шалгаж</u> заавар зөвлөгөө өгч ажиллаж байна. Зүүнбүрэн, Шаамар, Цагааннуур, Сант, Баруунбүрэн, Орхон, Түшиг, Алтанбулаг, Жавхлант, Сайхан сумдын Засаг даргын Тамгын газарт хийсэн удирдамжит шалгалтын явцад 24 төрийн захиргааны албан хаагчийн шалгалтанд тэнцсэнийг нотлох эх материалыг нөхөж хувийн хэргийг баяжуулахыг зөвлөж хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллалаа.
26.		Үр дүнгийн гэрээ	Төрийн албан хаагчийн 2013 оны үр дүнгийн гэрээг журмын дагуу дүгнэж авч хэрэгжүүлсэн арга хэмжээ	Төрийн албан хаагчийн 2013 оны үр дүнгийн гэрээний биелэлтийг төрийн захиргааны байгууллага бүр үнэлж төрийн захиргааны албан хаагчийн үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэлж дүгнэн, үнэлгээг үндэслэн төрийн албан хаагчийн цалингийн шатлал, ахиулах, зэрэг дэв шинээр болон ахулан олгох, мөнгөн урамшуулал олгох арга хэмжээг авч ажилласан байна. Аймгийн Засаг даргын 2014 оны А/89 дугаар захирамжаар 22 байгууллагын туслах, дэс, ахлах түшмэлийн ангиллын 98 төрийн албан хаагчид зэрэг дэв олгогдсон байна.
27.			2014 оны Төрийн албан хаагчийн үр дүнгийн гэрээг журмын дагуу байгуулсан байдал	Төрийн албаны зөвлөлийн 2012 оны 134 дүгээр тогтоолоор батлагдсан шинэчлэгдсэн журмын дагуу Төсвийн шууд захирагчийн, Менежерийн, Төрийн албан хаагчийн үр дүнгийн гэрээг байгуулан ажиллаж байна.
28.			Төрийн албан хаагчийн үр дүнгийн гэрээ байгуулах, дүгнэх асуудлаар төрийн байгууллагуудад мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлсэн ажиллагаа	Шаамар, Алтанбулаг, Сайхан сум, Номгон тосгонд зохион байгуулсан “Шалган туслах” ажлын хэсгийн удирдамжинд төрийн албан хаагчийн ажлын байрны тодорхойлолт, үр дүнгийн гэрээ байгуулсан, болон гэрээний биелэлтийг дүгнэсэн байдлыг шалгахаар тусган төрийн захиргааны албан хаагч бүртэй нэг бүрчлэн уулзаж заавар зөвлөгөө өгч ажиллалаа. Мөн аймгийн Нийгмийн халамжийн хэлтэс, Хүүхэд гэр бүл хөгжлийн хэлтсийн хүсэлтээр “Үр дүнгийн гэрээ байгуулах заавар, үнэлж дүгнэх журам”-ын талаар сургалт зохион байгуулан харилцан ярилцаж зөвлөгөө дэмжлэг үзүүллээ. Сүүлийн хагас жилд Баянгол, Хушаат суманд зохион байгуулахаар төлөвлөөд байна.
29.		Удирдах албан тушаалтны сонгон шалгаруулалт	2014 онд зарлагдсан сул орон тоо, зохион байгуулсан сонгон шалгаруулалтын тоо	Эхний хагас жилийн байдлаар Хэрх тосгоны цэцэрлэгийн эрхлэгч, Мандал сумын 2, 3 дугаар сургуулийн захирал, Сант сумын сургуулийн захирлын албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах 4 ажлын байрны зарыг Төрийн албаны зөвлөлийн

			цахим хуудсанд байршуулан зарлаж аймгийн Боловсролын газартай хамтран Төрийн албаны зөвлөлд хүсэлт гарган 2 удаа цахим хэлбэрээр зохион байгуулсан.
30.		Нөөцөд бүртгэж, нэр дэвшүүлсэн иргэний тоо /албан бичиг, салбар зөвлөлийн тогтоол/	Нийт зарлагдсан 4 ажлын байранд 13 хүн өрсөлдөж хамгийн өндөр авсан 4 хүнийг томилуулахаар аймгийн Боловсролын газраас нэр дэвшүүлсний дагуу Авлигатай тэмцэх газраас нийтийн ашиг сонирхлын зөрчлийн мэдүүлгийг уламжилж авах ажлыг зохион байгуулсан.
31.		Үүнээс томилогдсон албан хаагчийн тоо /бүртгэл судалгаа, эрх бүхий албан түшаалтны шийдвэр/	Аймгийн Засаг даргын захирамжаар хамгийн өндөр оноо авсан 4 хүнийг Хэрх тосгоны цэцэрлэгийн эрхлэгч, Мандал сумын 2, 3 дугаар сургуулийн захирал, Сант сумын сургуулийн захирлын албан тушаалд томилон ажиллуулж байна.
32.	Мэргэшлийн шалгалт	2014 онд зарлагдсан сул орон тоо, зохион байгуулсан сонгон шалгаруулалтын тоо	Төрийн албаны зөвлөлөөс нийтэд мэдээлсэн хугацааны дагуу 03 дугаар сарын 03-04-ний өдрүүдэд бүртгэлийг явуулж, нийт зарлагдсан 35 ажлын байраа шаардлагыг хангасан 280 иргэнийг бүртгэсэн. Сорилын шалгалтанд дэс түшмэлийн ангилалд 138 хүн бүртгүүлснээс 133 хүн биечлэн оролцож 32 хүн, туслах түшмэлийн ангилалд 142 хүн бүртгүүлснээс 130 хүн биечлэн оролцож 29 хүн тус тус тэнцлээ. Шинэчлэгдсэн журмын дагуу монгол хэлний мэдлэг болон албан хэрэг хөтлөх ур чадварын шалгалтанд хамрагдсан 61 хүнээс мөн цахим хэлбэрээр авахад дэс түшмэлийн 32 хүнээс 22, туслах түшмэлийн 29 хүнээс 26 хүн 9 ба түүнээс дээш оноо авч тэнцлээ. Шалгалтын эцсийн дүнгээр 48 хүн тэнцэж нөөцөд бүртгэгдсэн байна. 2014 оны 06 дугаар сарын 23-24-ны өдрүүдэд бүртгэлийг явуулж 21 байгууллагын 33 албан тушаалд 127 иргэн бүртгүүлсэн. Сорилын шалгалтанд дэс түшмэлийн ангилалд 45 хүн бүртгүүлснээс 41 хүн биечлэн оролцож 10 хүн, туслах түшмэлийн ангилалд 82 хүн бүртгүүлснээс 82 хүн биечлэн оролцож 13 хүн тус тус тэнцлээ. Шинэчлэгдсэн журмын дагуу монгол хэлний мэдлэг болон албан хэрэг хөтлөх ур чадварын шалгалтанд хамрагдсан 23 хүнээс мөн цахим хэлбэрээр авахад дэс түшмэлийн 10 хүнээс 10, туслах түшмэлийн 13 хүнээс 12 хүн 9 ба түүнээс дээш оноо авч тэнцлээ. Шалгалтын эцсийн дүнгээр 22 хүн тэнцэж нөөцөд бүртгэгдэхээр болсон. <u>Нийт 2014 оны эхний хагас жилийн байдлаар 70 хүн нөөцөд нэмж бүртгэгдэхээр болсон байна.</u>

33.			Нөөцөд бүртгэж, нэр дэвшүүлсэн иргэний тоо, /албан бичиг, салбар зөвлөлийн тогтоол/	Хагас жилийн байдлаар нөөцөөс нөхөх арга хэмжээг 2 удаа зохион байгуулан төрийн захиргааны дэс түшмэлийн 2 албан тушаалд- 2 хүн, туслах түшмэлийн 2 албан тушаалд -2 хүнийг тус тус бүртгэн Төрийн албаны салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэн холбогдох газруудад албан бичгээр нэр дэвшүүлсэн.
34.			Үүнээс томилогдсон албан хаагчийн тоо /бүртгэл судалгаа, эрх бүхий албан түшаалтны шийдвэр/	Төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтаар хамгийн өндөр оноо авч нэр дэвшүүлсэн дэс түшмэлийн 39, туслах түшмэлийн 40 хүн шалгалтанд хамгийн өндөр оноо авч нэр дэвшигдэн дэс түшмэлийн боловч дэс түшмэлийн ангилалд 10, туслах түшмэлийн ангилалд-8 хүн өөрийн хүсэлтээр болон ар гэрийн шалтгаанаар томилогдоогүй байна
35.	Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэнийг нөөц	Нөөцийн санг журамд заасны дагуу ангилан бүрдүүлсэн эсэх		Аймгийн хэмжээнд төрийн жинхэнэ албаны нөөцөд бүртгэлтэй 295 хүн байна. Үүнээс дэс түшмэлийн ангиллын 85, туслах түшмэлийн ангиллын 207 хүн нөөцийн жагсаалтанд бүртгэлтэй байна.
36.		2014 онд нөөцөөс нэр дэвшүүлсэн иргэний тоо /албан бичиг, салбар зөвлөлийн тогтоол/		Төрийн жинхэнэ албанд анх орох иргэдийн нөөцийн жагсаалтанд бүртгэлтэй байгаа тухай 22 хүнд Төрийн албаны салбар зөвлөлийн тодорхойлолт гаргаж өгсөн.
37.		Үүнээс томилогдсон иргэний тоо/бүртгэл судалгаа, эрх бүхий албан түшаалтны шийдвэр/		Үүнээс 10 хүн төрийн албаны төрийн захиргааны болон үйлчилгээний албан тушаалд томилогдон ажиллаж байна.
38.	Салбар зөвлөлийн үйл ажиллагааг олон нийтэд ил тод, нээлттэй сурталчилсан байдал	Цахим хуудастай эсэх		Төрийн албаны салбар зөвлөлийн тусгайлсан цахим хуудас байхгүй. Харин аймгийн selenge.gov.mn цахим хуудсанд “Нутгийн удирдлага” гэсэн талбарын “Төрийн албаны салбар зөвлөл” гэсэн хэсэгт салбар зөвлөлийн үйл ажиллагааг сурталчлан ажиллаж байна.
39.	Салбар зөвлөлийн үйл ажиллагааг олон нийтэд ил тод, нээлттэй сурталчилсан байдал	Орон нутгийн телевизээр сурталчилсан байдал/ баримтууд/		Төрийн албаны салбар зөвлөлийн үйл ажиллагааны талаар “TV-5” телевизийн мэдээллийн цагаарТөрийн албаны салбар зөвлөлийн дарга Ө.Сувдаа ярилцлага өгч мэдээлэл хийсэн. Мөн салбар зөвлөлийн үйл ажиллагааны талаар “Зууны мэдээ”, “Өглөөний сонин”, “Шинэ гэгээ”, “Сэлэнгийн мэдээ” зэрэг сонинд мэдээ, мэдээлэл өгч, төрийн албаны мэргэшлийн шалгалтын зарыг орон нутгийн “Миний монгол” телевизээр тогтмол сурталчлан ажиллаж байна.

40.			Орон нутгийн сониноор сурталчилсан байдал /Сонин хэвлэгдсэн /	Аймгийн “Иргэн танаа” сар бүрийн мэдээллийн сонинд Төрийн албаны салбар зөвлөлөөс зарласан жилийн сурталчилгааг хийж, аймгийн хэмжээний төрийн албан хаагчийн тоо бүртгэл, шалгалтын үр дүнгийн талаарх мэдээллийг тогтмол гарган сурталчилж ажиллаж байна.
41.	Батлагдсан бүтэц орон тоогоор ажиллаж буй эсэх, Төрийн албан хаагчийг томилж, чөлөөлсөн тухай эрх бүхий албан тушаалтны шийдвэртэй танилцаж, зөвлөмж өгөх /2012 оны сүүлийн хагас, 2013, 2014 он/		Нутгийн захиргааны байгууллагад	Нутгийн захиргааны байгууллага бүр батлагдсан бүтэц, орон тооны дагуу ажиллаж байна. Өсвийн ерөнхийлөн захирагч, төсвийн шууд захирагч нарын хүний нөөцийн холбогдол бүхий шийдвэрийн төсөлд аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль зүйн хэлтэс хянан магадалж арга зүйн зөвлөгөө дэмжлэг үзүүлэн ажиллаж байна. Мөн шийдвэрийн үндэслэлийг хэрхэн зөв хангаж ажиллах талаар тараах материал бэлтгэн бүх төр төсвийн байгууллагад хүргүүлж, шаардлагатай зарим байгууллагад биечлэн зөвлөгөө өгч ажиллаж байна.

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН

САЛБАР ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

/ Ө.СУВДАА/

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

/Д.ГАН-ОТГОН/

**МОНГОЛ УЛСЫН ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ЗӨВЛӨМЖИЙН
ХЭРЭГЖИЛТ**

2014.06.30

Төрийн албаны зөвлөлийн 2014 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн 148 дугаар албан бичгээр ирүүлсэн “Том төрөөс ухаалаг төр лүү” санаачлагыг дэмжиж Төрийн албаны зөвлөлийн зөвлөмжийн хоёрдугаар хэсгийн “төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлүүдэд” гэсэн 6 заалтын хэрэгжилтийг дараах байдлаар тайлагнаж байна.

№	Зөвлөмжийн заалт	Гүйцэтгэл	Хувь
1	Салбар зөвлөлөөс гарч байгаа төрийн албан хаагчтай холбоотой бүх шийдвэр нь хууль тогтоомжинд нийцсэн байх зарчмыг тууштай хэрэгжүүлэх	Төрийн албаны салбар зөвлөл эрх хэмжээнийхээ хүрээнд 14 тогтоол, 64 албан бичгийг хууль тогтоомжинд нийцүүлэн гаргасан байна.	100
2	Төрийн албаны удирдах болон гүйцэтгэх албан тушаалын сонгон шалгаруулалт явуулж, нэр дэвшүүлэхдээ “Мерит”-ийн зарчимд тулгуурлан, аливаа байгууллага, албан тушаалтны зүй бус нөлөөллийн ангид явуулах	Төрийн албаны удирдах болон гүйцэтгэх албан тушаалын сонгон шалгаруулалтыг зохион байгуулан Төрийн албаны хуулийн 17 дугаар зүйлд заасанчлан хамгийн өндөр оноо авсан иргэнийг нэр дэвшүүлэн томилуулах ажлыг мэргэшил арга зүйн удирдлагаар ханган ажиллаж байна.	90
3	Төрийн албан хаагчдын сонгон шалгаруулалтын бүхий л үйл явцыг олон нийтэд нээлттэй, ил тод байлгаж, энэ чиглэлээр иргэдийн хяналт тавих, мэдээлэл авах эрхийг хууль тогтоомжийн хүрээнд хангаж ажиллах	2014 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн Төрийн албаны мэргэшлийн шалгалтын үйл явцыг олон нийтэд нээлттэй, ил тод байлгах үүднээс 2 танхимд зохион байгуулагдаж байгаа шалгалтын явцыг эхлэхээс нь дуустал нь дэлгэцээр ажиглан харах боломжийг бүрдүүлж өгсөн байна. Шалгалт хэрхэн явагдаж байгааг гадаа коридорт дэлгэцээр харуулж байсан нь шалгуулагч иргэд болон олон нийтийн сэтгэлд нийцсэн шинэлэг арга хэмжээ болжээ. Энэ тухай мэдээллийг Төрийн албаны зөвлөлийн болон аймгийн цахим хуудсаар иргэдэд мэдээлэх ажлыг зохион байгууллаа.	100
4	Төрийн албан хаагчид, үүний дотор төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэх талаар төрийн албаны төв байгууллагаас батлан гаргасан стандарт, журмыг хэрэгжүүлэх ажлыг мэргэшил, арга зүйн удирдлагаар хангахад онцгой анхаарч, үнэн зөв, бодитой үнэлгээ өгөх нөхцөлийг бүрдүүлэхэд нь төрийн байгууллагуудад туслалцаа, дэмжлэг үзүүлж ажиллах	Төрийн төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэх талаар Төрийн албаны зөвлөлөөс батлан гаргасан стандарт, журмыг хэрэгжүүлэх ажлыг мэргэшил, арга зүйн удирдлагаар хангахад үйл ажиллагаагаа чиглүүлэн Жавхланта суманд зохион байгуулагдсан Ерөө бүсийн төрийн албан хаагчдын нэгдсэн зөвлөгөөн, Баянгол сумын “Төийн албан хаагчдын өдөрлөг”-т оролцож заавар зөвлөгөө өгч ажиллалаа.	90
5	Төрийн байгууллагуудын төрийн албан хаагчдыг чадавхижуулах сургалт, хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжилтэнд онцгой анхаарах, шаардлагатай	Төрийн албаны өөрчлөлт, шинэчлэлтийн өнөөгийн чиг хандлага нь мэдлэг чадвартай мэргэшсэн төрийн албан хаагчдаар иргэдэд чанартай, хүртээмжтэй төрийн үйлчилгээг үзүүлэх	

	тохиолдолд шинэ шаардлагад нийцүүлэн хөтөлбөрийг нь шинэчлүүлэх арга хэмжээ авах	хэрэгцээ шаардлагын үүднээс <u>“Төрийн албан хаагчийн мэдлэг чадвар”</u> хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор нийт сум, агентлагуудад өөрсдийн онцлогт нийцүүлсэн сургалтын хөтөлбөрийг боловсруулах үүрэг, чиглэлийг өгч, хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллалаа.	90
6	Салбар зөвлөлүүд харъяа байгууллагууддаа “Ухаалаг төр”-ийн зарчим хэрхэн хэрэгжиж буй талаар олон нийтийн үнэлгээнд тулгуурласан байдлыг хагас, бүтэн жилээр үнэлгээ, дүгнэлт өгч үр дүнг тооцон ажиллах	Төрийн албаны салбар зөвлөлөөс 2014 оны <u>“Төрийн албан хаагчийн ажлын хариуцлага, ёс зүйг дээшлүүлэх жил”</u> болгон зарлаж түүнийг хэрэгжүүлэх 15 багц ажлын чиглэлийг хүргүүлэн биелэлтийг хагас бүтэн жилээр авч байна. Төрийн байгууллагуудын ажил үйлчилгээ, төрийн албан хаагчийн ажлын хариуцлага, ёсзүй, тэдгээрийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшний үнэлгээнд иргэдийн сэтгэл ханамж, үнэлэмжид тулгуурлан үнэлэх зорилгоор <u>“Олон нийтийн оролцоо-төрийн үйлчилгээ”</u> хөтөлбөрийг боловсруулан аймгийн ИТХТ-ийн хуралдаанаар хэлэлцүүлэн 165 дугаар тогтоолоор баталж хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор <u>“Үйлчлүүлэгчдээс Төрийн байгууллага, албан хаагчдын үйл ажиллагааны талаар санал асуулга авах журам”</u> -ыг аймгийн Засаг даргын захирамжаар батлан хэрэгжүүлэн ажиллаж байна.	70
	Гүйцэтгэлийн дундаж хувь		90,0

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛ

**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН 2014 ОНЫ 03 ДУГААР САРЫН 18-НЫ ӨДРИЙН
350 ДУГААР АЛБАН БИЧГЭЭР ИРҮҮЛСЭН ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ**

2014.06.30

№	Зөвлөмжийн заалт	Гүйцэтгэл	Хувь
1	Орон нутгийн бүр шатны төрийн байгууллагууд Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Төрийн албаны зөвлөлөөс хүргүүлсэн зөвлөмжийн дагуу тодорхой ажил зохион байгуулж, Ерөнхийлөгчийн санаачлагыг дэмжин хэрэгжүүлэх арга хэмжээг төсвийн шууд захирагч, төсвийн ерөнхийлөн захирагчийн 2014 оны үр дүнгийн гэрээнд тусгах	Аймгийн Засаг даргын эрхлэх асудлын хүрээний хэлтэс агентлагуудын нийт 21 дарга төсвийн шууд захирагч нарын үр дүнгийн гэрээ болон 17 сумын Засаг дарга нарын бүтээгдэхүүн нийлүүлэлт, санхүүжилт авах гэрээний хавсралтанд “Том төрөөс ухаалаг төр лүү” санаачлагыг дэмжин хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах талаар тусгайлан заалт оруулж тусган хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллаж байна	100
2	Төрийн албан хаагчийн бүрэлдэхүүн хөдөлгөөний тайланд төрийн албан хаагчийн мэдээллийг тухай бүр оруулж хэвших, бүрэлдэхүүн хөдөлгөөний тайланг бодит байдалтай тулган шалгах ажлыг 2014 оны эхний хагас жилд багтаан харъяа байгууллагуудын хэмжээнд зохион байгуулах	Сумдын Засаг даргын Тамгын газрын төрийн захиргаа, хууль эрх зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн болон хэлтэс агентлагийн хүний нөөцийн асуудал хариуцсан ажилтан, санхүүч албан тушаалын чиг үүрэгт хамааруулан Төрийн албан хаагчийн бүрэлдэхүүн хөдөлгөөний тайлангийн программыг компьютерт нь суулган өгч мэдээллийн баазыг суулгаж өгснөөр тайланг тухай бүр хийж байх нөхцөл бүрдсэн. Эхний хагас жилийн байдлаар Зүүнбүрэн, Шаамар, Цагааннуур, Сант, Баруунбүрэн, Орхон, Түшиг, Алтанбулаг, Жавхлант, Сайхан сумдын Засаг даргын Тамгын газарт хүний нөөцийн төлөвлөлт хэрэгцээ хангалтын талаар зохион байгуулж буй байдалд шалгалт хийж заавар зөвлөгөө өгч ажиллалаа.	100
3	Түр орлон гүйцэтгэгчийг томилон ажиллуулж байгаа төрийн захиргааны удирдах болон гүйцэтгэх албан тушаалын сул орон тоог нийтэд нээлттэй зарлаж сонгон шалгаруулалтыг 2014 оны 2 дугаар улиралд багтаан зохион байгуулах	Удирдах ажилтны сонгон шалгаруулалт болон төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тооны захиалгыг тухай бүр Төрийн албаны зөвөлийн болон аймгийн цахим хуудсанд нээлттэй байршуулан зарласан. 2014 оны эхний хагас жилийн байдлаар удирдах ажилтны сонгон шалгаруулалтаар зарлагдсан 4 ажлын байранд 13 хүн өрсөлдөж хамгийн өндөр авсан 4 хүн томилогдон ажиллаж байна. Эхний 6 сарын байдлаар төрийн жинхэнэ албан тушаалын нийт 53 сул орон тоог нээлттэй зарлаж 2 удаа төрийн албаны мэргэшлийн шалгалт зохион байгуулагдан дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд 32 иргэн нөөцөд бүртгэгдэж 18 хүн нэр дэвшсэн, туслах түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд 38 иргэн нөөцөл бүртгэгдэж 13 иргэн нэр дэвшсэн байна.	100

4	Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 105, 128 дугаар тогтоолоор тус тус баталсан “Төрийн албаны зөвлөлийн бүрэлдэхүүний нийтлэг жишиг”, “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-д нийцүүлэн салбар зөвлөлийн гишүүдийн ажил үүргийн хуваарийг шинэчлэн баталж мөрдүүлэх	Төрийн албаны зөвлөлийн шийдвэрээр аймгийн Төрийн албаны салбар зөвлөл 11 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж байна. Салбар зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга, гишүүд журмын хүрээнд ажил үүргийн хуваарийг шинэчлэн баталж мөрдөн ажиллаж байна. Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журмын дагуу 12 эрх, 9 нийтлэг эрх, 5 тусгай үүргийг хэрэгжүүлэх ажлыг орон нутгийн хэмжээнд зохион байгуулан ажиллаж байна.	90
5	Салбар зөвлөлд ирүүлсэн өргөдөл, гомдлыг хугацаанд нь хянан шийдвэрлэх	Аймгийн Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд Төрийн албатай холбоотой асуудлаар 6 төрийн албан хаагчийн өргөдөл, гомдол ирснийг бүртгэн холбогдох хууль журмын дагуу тухай бүр нь Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн гишүүдээр ахлуулсан ажлын хэсэг томилон дүгнэлт гаргуулж, салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэн хуулийн хугацаанд нь шийдвэрлэж ажиллалаа	100
6	Удирдах ажилтны нөөц, төрийн албанд анх орох иргэний болон төрийн жинхэнэ албан хаагчийн нөөцийн журамд заасан төрөл тус бүрээр ангилан бүрдүүлэх	Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалын нөөцөд-2, төрийн үйлчилгээний удирдах ажилтны нөөцөд 3 иргэн бүртгэлтэй байна. Аймгийн хэмжээнд төрийн жинхэнэ албаны гүйцэтгэх албан тушаалын нөөцөд бүртгэлтэй 295 хүн байна. Үүнээс дэс түшмэлийн ангиллын 85, туслах түшмэлийн ангиллын 207 хүн нөөцийн жагсаалтанд бүртгэлтэй байна.	90
7	Төрийн байгууллагуудад батлагдсан бүтцийн хүрээнд ажиллаж байгаа эсэх, төрийн албан хаагчдыг томилж, чөлөөлөх, халах асуудал хуулийн хүрээнд хийгдэж байгаа эсэх зэрэг асуудлаар хяналт шинжилгээ хийх, зөрчлийг арилуулах, заавар зөвлөгөө өгөх ажлыг зохион байгуулах	Аймгийн хэмжээнд зохион байгуулсан “Ээлтэй үйлчилгээг иргэн танд” арга хэмжээний хүрээнд 17 суманд, аймгийн Засаг даргын нэрэмжит үзлэгийг Сайхан, Зүүнбүрэн сум, Номгон тосгон, “Шалган туслах” арга хэмжээг Алтанбулаг, Шаамар сум, Дулаанхаан тосгонд тус тус зохион байгуулж, төсвийн шууд захирагч нарын шийдвэрийн эрх зүйн үндэслэлийг магадлан шалгаж заавах зөвлөгөө дэмжлэг үзүүлж ажилласан. Мөн эрх зүйн туслалцааны <u>70363535, 70363834, 70363199</u> шууд утсаар хууль эрх зүйн сургалт сурталчилгааны ажлыг шуурхай удирдлага зохицуулалтаар ханган ажиллаж байна.	90
Гүйцэтгэлийн дундаж хувь			95,7

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛ